

ОХУ-ЫН ТӨРИЙН ЭРХ БАРИГЧ СУБЪЕКТУУДЫН ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ

*К.Дэмбэрэл**

Энэхүү өгүүлэлд ОХУ-ын улс төрийн тогтолцоог бүрдүүлэгч үндсэн субъектууд болох Ерөнхийлөгчийн, Холбооны хурлууд, Засгийн газрын эрх, үүргийн хуваарилалт нь хуулиар хэрхэн зохицуулагдаж буйг харуулахыг зорилоо.

ОХУ-ын улс төрийн тогтолцооны төлөвшил

1991 онд Б.Ельцин бүх нийтийн санал хураалтаар 57%-ийн санал авч ОХУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон ба 1993 оны 10 сард дэд ерөнхийлөгч А.Руцкойн бүрэн эрхийг зогсоож, парламент буюу Дээд Зөвлөлөө тараасан нь хууль зүйн хувьд алдаатай байсан хэдий ч өөрчлөлт, шинэчлэлт, ардчиллыг урагшлуулах алхам байлаа. Ельцины энэ алхмыг Өрнөдөд дэмжсэн маягаар өнгөрөөсөн. Дээд Зөвлөлөө цэргийн хүчээр тарааж, түүний спикер Р.Хасбулатов, дэд ерөнхийлөгч А.Руцкой нарын талынхныг “Лефортов”-т суулгахад армийн дээд удирдлагын дор хаяад 2/3 нь Ельцины талд байсан явдал нөлөөлсөн.

1993 оны 12 сарын 12-нд батлагдсан ОХУ-ын шинэ үндсэн хуульд Ерөнхийлөгчийн засаглалтай, хоёр танхим бүхий парламенттай, холбооны БНУ хэмээн тунхагласан. Уг үндсэн хуулиар түүнд засвар оруулах, зарим зүйлийг эргэн харах тухай саналыг Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Төрийн Дум, Засгийн газар, ОХУ-ын субъектуудын хууль тогтоох байгууллагууд, түүнчлэн Холбооны Зөвлөл, Төрийн Думын депутатуудын 1/5 – ээс багагүй тоотой депутатын бүлэг санал оруулах эрхтэй.

1993 оны 12 сард Төрийн Думын сонгуулийг холимог системээр явуулж парламентын доод танхимд улс төрийн 6 хүчин нийт суудлыг хуваасан.

1995 оны Төрийн Думын сонгуульд олонхи болсон Оросын Коммунист Нам тэргүүтэй зүүний хүчин Б.Ельцины хувьд хүчтэй сөрөг хүчин байсан.

1999-2003 оны Төрийн Думд зүүний хүчин нийт суудлын 24 илүү хувьтай байсан ч төвийн хүчин болох “Единство”, түүнийг дэмжсэн баруун төвийнхэний нөлөө хүчтэй байснаас энэ үед ерөнхийлөгчийн бодлого тууштай хэрэгжих таатай нөхцөл бүрдсэн.

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

2003 оноос Ерөнхийлөгчийн талыг баримтлагч хүчнүүд олонхи болж Төрийн Дум, Ерөнхийлөгч хооронд “хамгийн зохистой” харьцаа үүссэн. Харин 2007 оноос энэ харьцаа улам ч тааламжтай болох нь сая өнгөрсөн орон нутгийн сонгуулийн дүн харуулж байна.

Б. Ельцин ерөнхийлөгч байхдаа аль нэг улс төрийн намаас аль болох “ангид” байхыг эрмэлзэж байсан үеийг бодвол В.Путин ерөнхийлөгч болсноосоо хойш улс төрийн тодорхой хүчнийг зарим талаараа илүү үздгээ нуухгүй байгаа төдийгүй 2007 оны Төрийн Думын сонгуульд “Единство”-г шууд дэмжсэн. Энэ дэмжлэгийн дүнд улс төрийн хүчин “Единство” нь парламентад “үнэмлэхүй” олонхи болж чадсан. Улс төрийн хүчнүүдийн одоогийнх шиг харьцаа 1993 оноос хойш байгаагүй.

2000 оноос эхлэн ямар бодлогыг хэрхэн хэрэгжүүлсэн бэ

1. Ерөнхийлөгчийн засаглалыг хүчтэй болгох үүднээс улс төрийн томоохон өөрчлөлт явуулсан нь улсын хэмжээний болон субъектуудын улс төрийн үйл явцыг үндсээр өөрчилсөн. Үүнд: субъектуудын хууль тогтоох байгууллагуудын депутатуудын 50-аас доошгүй хувийг сонгуулийн пропорциональ системээр зайлшгүй явуулах заалт, Холбооны Зөвлөл буюу Оросын парламентын дээд танхимыг бүрдүүлэх журамд өөрчлөлт оруулж, тэндээс субъектуудын амбан захирагч, хурлын дарга нарыг гаргасан, субъектуудад сонгуулийн өмнөх эвсэл, улс төрийн намууд байхыг хориглосон, амбан захирагч нарыг сонгуулиар бус дээрээс томилдог болгосон, намын нэрээр сонгогдох босгыг алгуур өндөрсгөв.

2. Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь үндсэн хуульт-төрийн өөрчлөлт байсан. Холбооны засгийн үүргийг нэмэгдүүлэн, засаглалын босоо тогтолцоог бэхжүүлсэн, үүнтэй холбоотойгоор Холбооны тойргуудад Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгчийг томилсон.

3. Ерөнхийлөгчийн зарлигаар гүйцэтгэх засаглалын тогтолцоонд багтсан Төрийн зөвлөлийг байгуулсан ба түүнд субъектуудын удирдлагууд багтах болсон.

4. Холбооны Зөвлөлийг сонгуулиар байгуулах болсон.

5. Бусад улсуудын зүгээс Оросын сонирхлын бүс, эрх ашигт шууд хүч түрэх болсон явдал улс орныг “хүчтэй гарт” байлгаж эрх ашгаа хамгаалах бас нэг бодит шаардлага бий болсон.

6. Барууны болон баруун төвийн чиглэлтэй улс төрийн хүчнүүдийн байр суурь суларч, центрист, зүүн болон зүүн төвийн улс төрийн хүчнүүдийн байр суурийн бэхжилт хүчтэй ерөнхийлөгчийн засаглалыг улам бэхжүүлсэн. 2001 онд батлагдаж, 2006 онд шинэчлэгдсэн “Улс төрийн намуудын тухай” хуулиар тэдгээрийг “цэгцлэх” бодлогыг явуулж байна. Улс төрийн намуудын хэмжээнд ОКН, ЛАН хоёр л төлөвшөөд байгаа.

Хүчтэй Ерөнхийлөгчийн засаглалын давуу тал нь юу вэ

1. Улс төрийн тогтвортой байдал бий болгох боломж нээлттэй болно.
2. Хариуцлага тооцох боломж нээлттэй болно.
3. Залгамжлагчаа тодруулахад хүчтэй нөлөөлөх боломжтой.
4. Тулгамдсан асуудалд шуурхай арга хэмжээ авах боломж илүү нээлттэй

Хүчтэй Ерөнхийлөгчийн засаглалын сул тал нь юу вэ

1. Ерөнхийлөгчийг хэт ганцаардмал байдалд оруулдаг
2. Улс төрийн ихээхэн хаалттай системийг бүрдүүлэх боломжтой
3. Хэдийгээр сонгуулиар төр, засгийн эрх шилжүүлнэ гэдэг хэдий ч засаглалыг үе залгамжлах шинж рүү түлхдэг. Энэ нь олон намын тогтолцоог хадгалж буй төрхтэй боловч үнэн хэрэгтээ улс төрийн намуудын өрсөлдөөний сонгодог утгыг алдагдуулна.
4. Иргэдэд мэдээлэл, үйл явдал бүрэн эхээрээ бус хүрдэг
5. Политтехнолог Г.Павловскийн тэмдэглэснээр, “Оросын Ерөнхийлөгч нь аль нэг намын гишүүн байх нь зүйтэй бөгөөд эс тэгвээс ойрын 2-3 сонгуулийн циклийн дараагаар энэ засаглал нь үндсэн хуульт монархизм болж хувирах” аж.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрх нь үндсэн хуулиндаа тодорхойлсноор:

1. Төрийн Думтай зөвшилцөн Засгийн газрын тэргүүнийг томилно
2. Засгийн газрын хуралдааныг даргалах эрхтэй.
3. Засгийн газрыг огцруулах шийдвэр гаргана.
4. Төв Банкны тэргүүнийг томилох, огцруулах саналыг Төрийн Думд оруулдаг.
5. Засгийн газрын тэргүүний санал болгосон Засгийн газрын орлогчид, гишүүдийг томилох ба огцруулах эрхтэй.

6. Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх, Арбитрийн шүүгчид болон Ерөнхий прокурорыг томилох, огцруулах саналыг Холбооны Зөвлөлд оруулна.
7. Аюулгүйн Зөвлөлийг бүрдүүлэн түүнийг удирдана.
8. Цэргийн доктриныг батална.
9. Ерөнхийлөгчийн тамгын газрыг бүрдүүлнэ.
10. Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгчдийг томилох, чөлөөлөх.
11. Зэвсэгт хүчний дээд удирдлагыг томилох, чөлөөлөх.
12. Холбооны зөвлөлийн зохих хороодтой зөвлөлдөн гадаад улсуудад, олон улсын байгууллагуудад элчин төлөөлөгч томилох, эргүүлэн татах ажлыг хийнэ.

ОХУ-ын Ерөнхийлөгч нь:

1. Үндсэн хууль, бусад хуулийн хүрээнд Төрийн Думын сонгуулийг товлон.
2. Үндсэн хуулинд заагдсны дагуу Төрийн Думыг татан буулгана.
3. Хуулийн дагуу бүх нийтийн санал асуулгыг товлон.
4. Төрийн Думд хуулийн төсөл оруулна.
5. Хуульд гарын үсэг зурж хүчин төгөлдөржүүлнэ.
6. Холбооны хуралд парламентад улс орны өнөөгийн байдал, дотоод гадаад улс төрийн бодлогын талаар жил бүр илгээлт гаргана.
7. Иргэншил болон улс төрийн орогнолын асуудлыг шийднэ.
8. Төрийн дээд шагналаар шагнах, хүндэт цолыг хүртээх, цэргийн болон бусад тусгай дээд цолыг хүртээнэ.
9. Өршөөл үзүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Холбооны Зөвлөл өөрийн эрх мэдлийн хүрээнд дараахи үйл ажиллагааг явуулна.

1. ОХУ-ын субъектуудын хилийн өөрчлөлтийг батлах
2. Цэргийн байдал зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
3. Онц байдал зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
4. Зэвсэгт хүчнийг Оросын нутаг дэвсгэрээс гадагш илгээх асуудлыг шийдэх
5. Ерөнхийлөгчийн сонгуулийн товыг тогтоох
6. Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь түдгэлзүүлэх
7. Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх, Арбитрийн шүүгчдийг үүрэгт ажилд нь томилох

8. Ерөнхий прокурорыг томилох, огцруулах.
9. Ерөнхий аудиторын орлогч даргыг үүрэгт ажилд нь томилох, чөлөөлөх ба аудиторуудын бүрэлдэхүүний хагасыг хүртэл үүрэгт ажилд нь томилох, чөлөөлөх
10. Үндсэн хуулийн хүрээн дэх эрхийн дагуу тогтоол гаргах ба уг тогтоолыг ердийн олонхийн саналаар баталдаг.

Төрийн Дум нь эрх мэдлийнхээ хүрээнд дараахи үйл ажиллагааг явуулна.

1. Засгийн газрын тэргүүнийг томилоход Ерөнхийлөгчид зөвшөөрөх
2. Засгийн газарт итгэл үзүүлэх асуудлыг шийдэх
3. Төв Банкны тэргүүнийг томилох, огцруулах
4. Ерөнхий аудиторыг үүрэгт ажилд нь томилох, чөлөөлөх ба аудиторуудын бүрэлдэхүүний хагасыг хүртэл үүрэгт ажилд нь томилох, чөлөөлөх
5. Хүний эрхийн асуудлаархи бүрэн эрхт төлөөлөгчийг үүрэгт ажилд нь томилох, чөлөөлөх
6. Цагаатгах асуудал
7. Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас огцруулахаар буруутгах үндэслэлийг гаргах

Засгийн газар нь өөрийн эрх мэдлийн хүрээнд дараахи үйл ажиллагааг явуулна.

1. Төрийн Думд улсын нэгдсэн төсвийг боловсруулах, өргөн барих ба түүний гүйцэтгэлийг хангах, улсын төсвийн гүйцэтгэлийн тухай тайланг Төрийн Думд өргөн барих
2. Улсын санхүү, зээл, мөнгөний нэгдсэн бодлого явуулахыг хангах
3. Улсын соёл, шинжлэх ухаан, боловсрол, эрүүлийг хамгаалах, нийгмийн хамгаалал, экологийн нэгдсэн бодлого явуулахыг хангах
4. Улсын өмчийн удирдлагыг хангах , хэрэгжүүлэх
5. Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, гадаад бодлогыг хэрэгжүүлэх
6. Иргэний эрх чөлөө, хууль ёс, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, өмчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх
7. Түүнчлэн үндсэн хууль, ерөнхийлөгчийн зарлиг, бусад хуульд заагдсан эрхийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэх

Дүгнэлт

Улс төрийн нам, хөдөлгөөнүүд бүхэн олон янзын хөтөлбөр, санал санаачилга дэвшүүлдэг хэдий ч амьдрал дээр тэдгээр нь агуулгын хувьд давхцдаг буюу нийтлэг тал ихтэй. Оросын парламентад Монголын лобби бүлэг байгуулах боломж бий. Энэ нь Монголын талаархи аливаа асуудалд зохих хэмжээгээр нөлөөлөх нь зүйн хэрэг. Хэтдээ Оросын парламентад Монголын талаар, Монгол-Оросын харилцааны асуудлаар ойлголт муутай хүмүүс орж ирснээр аливаа асуудлууд шийдэгдэхэд төвөгтэй болох тул энэ лобби бүлгийг бий болгон ажиллуулах тал дээр улсаас санаачилгатай хандах нь зүйтэй.

Үндсэн хуулинд заасан бүрэн эрхийн хэмжээнд Ерөнхийлөгчийн үүрэг хариуцлага яригддаг ба харин түүний илүү эрх мэдэл, “дарангуйлал” мэтийн асуудал бол Парламентад Ерөнхийлөгчийг “дагагсад” буюу түүний талыг баримтлагсад олонхи болсноор бий болох нөхцөл бүрдэнэ.

Улс төрийн намуудын төлөвшил хараахан бэхжээгүй буюу улс төрийн тогтолцоонд улс төрийн нам үндсэн нэг элемент нь болж төлөвшөөгүй байгаа нь ерөнхийлөгчийн хүчтэй засаглал орших бас нэг нөхцөл болсон. В.Путин 2-3 улс төрийн нам ирээдүйд улс орныг авч явах байх гэсэн санааг аль 2001 онд цухалзуулсан. Гэхдээ энэ нам нь олон нийтийн дэмжлэг хүлээсэн, тогтвортой нэр хүндтэй байх ёстойг давхар сануулсан. Ардчилсан нийгэмд ард түмэн, засаг төрийн хоорондын байнгын холбогч гүүр нь улс төрийн нам гэдгийг ч тодорхой хэлсээр л байгаа. Орост улс төрийн намууд сонгодог утгаараа бүрэлдэн тогтоход дор хаяж 2 сонгуулийн хугацаа шаардлагатай байгаа. Хэтдээ Ерөнхийлөгчийг улс төрийн аль нэг намаас дэвшүүлэх нь зүйтэй гэдэгт В.Путин санал нэг байсан.

Хэдий хүчтэй Ерөнхийлөгч байсан ч улс төрийн аль нэг намаас харъяалагддаг байх нь түүнд том тулах хүчин болно. ОХУ бий болсон үеэс л түүний удирлагын зүгээс өмнөө тавьж ирсэн гол зорилго бол ОХУ-ыг задлахгүй байх явдал байсан. Харин процессыг шийдсэн нөхцөлд дараагийн зорилт нь хуучин ЗХУ-ын нөлөөний хэмжээнд Оросын нөлөөг сэргээх явдал байгаа. Энэ нь хэдийгээр амбиц мэт боловч сүүлийн үеийн үйл ажиллагаанууд нь түүнийг зөвтгөж болохоор байгаа. Эдгээр үйлдэл нь том улсуудын сонирхолтой зөрчилдөх бөгөөд түүнийг хэрхэн давах нь Оросын удирдлагын стратегийн асуудал.

Өнөөгийн ОХУ-ын улс төрийн систем нь хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан бараг бүх БНУ-уудад давтагдаж байгаа систем. ОХУ нь Ерөнхийлөгчийн хамгийн өргөн эрх мэдэлтэй БНУ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Конституция Российской Федерации. Принята всенародным голосованием 12 декабря 1993 г. М., 1993.
2. Разделение властей: История и современность. Спецкурс /Отв. ред Н.М. Марченко. М., 1996.
3. Рогачев С.В. Российская государственность в системе трансформационных координат. М., 2000.
4. Истон Д. Категории системного анализа политики. Антология мировой политической мысли т.2 М.1997. С. 629 - 642.
5. Соловьев А.И. Политология. Политическая теория. Политические технологии. М., 2000.
6. Представительная власть в России: история и современность /под общей ред. Л.К. Слиски. М., РОССПЭН, 2004.
7. Шнайдер Э. Политическая система Российской Федерации /пер. с нем., М., ИНИОН, 2002.
8. Политические институты на рубеже тысячелетий: XX в. - XXI в. /В.И. Борисюк, Г.И. Вайнштейн, И.Е. Городецкая и др.; Отв. ред. К.Г. Холодковский. - Дубна: Феникс+, 2001. Раздел III. С. 396-478.
9. Согрин В.В. Политическая история современной России. 1985-2001: от Горбачева до Путина. М., 2001.
10. Формирование партийно-политической системы в России. М., 1998.
11. Шевцова Л.Ф. Режим Бориса Ельцина, М., 1999.
12. Федеральный закон «О политических партиях». М, 2001.
13. Политические партии России: история и современность, М., 2000.
14. Гельман В.Я. О становлении российской партийной системы и практиках политических коалиций // Полис, 1997, №3, С. 188-191.
15. Коргунюк Ю.Г., Заславский С.Е. Российская многопартийность /Становление, функционирование, развитие/. М., 1996.
16. Политические партии и движения на выборах 1999 г. М., 2000.
17. www.kremlin.ru
18. www.vz.ru
19. www.kasparov.ru/
20. <http://kprf.ru/>
21. <http://www.politonline.ru>
22. <http://annews.ru/>
23. <http://www.polit.ru>